



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны
зуучлагч /брокер/-дын тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 10.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2, 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэ тогтоолын хавсралтад нэр дурьдсан Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд сунгасан талаарх тэмдэглэгээг 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хийлгэхийг Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дын гүйцэтгэх захирлуудад үүрэг болгосугай.
3. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-дын тусгай зөвшөөрөл сунгах зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 100,000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тогтоосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000111

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 109 дугаар тогтоолын хавсралт



Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ын тусгай зөвшөөрөл сунгах нэр бүхий 26 компани

1. “Ханбүргэд хэнтий ХААБ” ХХК
2. “Хонгорын таван эрдэнийн хишиг ХААБ” ХХК
3. “Өвөр таван эрдэнийн шим ХААБ” ХХК
4. “Цэц-Инвест ХААБ” ХХК
5. “МЭТУ ХААБ” ХХК
6. “Бадархундага оргил ХААБ” ХХК
7. “Мөрөнтаван эрдэнэ ХААБ” ХХК
8. “Алтан шагай импекс ХААБ” ХХК
9. “Хаантэлмэн ХААБ” ХХК
10. “Бурхант таван эрдэнэ ХААБ” ХХК
11. “Вүүдсоунд ХААБ” ХХК
12. “Интерлогик ХААБ” ХХК
13. “ҮСҮ ХААБ” ХХК
14. “Батбилгэх ХААБ” ХХК
15. “Гурван цаст гал тамга ХААБ” ХХК
16. “Увс таван эрдэнийн ундарга ХААБ” ХХК
17. “Хөвчийн тал ХААБ” ХХК
18. “Өлгий түүхий эд ХААБ” ХХК
19. “Бурналасан-Од ХААБ” ХХК
20. “Гүүдкомэкс ХААБ” ХХК
21. “Сантланс ХААБ” ХХК
22. “Танандээж трейд ХААБ” ХХК
23. “Ийзиплас ХААБ” ХХК
24. “Баярплант ХААБ” ХХК
25. “Стандарт таваар ХААБ” ХХК
26. “Хааннэгдэл ХААБ” ХХК